



**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН
АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2012 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Тохижилтийн зардал шийдэх тухай

Монгол Улсын "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай" хуулийн 17.1.1, 17.1.6, 17.1.7 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газраас 2009 онд хэрэгжүүлэгч агентлаг, харъяа газрууд өөрийнхөө байрлаж байгаа давхрын коридор, ариун цэврийн өрөө болон албан тасалгааныхаа өнгө үзэмж тохижилтийг сайжруулах болзолт уралдаан зарласны дагуу "Хангарьд ордоны" 4 давхарт ханы усан оргилуур хийх тохижилтийн ажлыг зохих журмын дагуу зохион байгуулсугай.

2. Ханын усан оргилуур, тохижилтийн ажлыг хийлгэх зардал болох 6.212.200 /зургаан сая хоёр зуун арван хоёр мянга хоёр зуун/төгрөгийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэстэй зөвшилцөн, холбогдох зардлаас гаргахыг ня-бо /П.Ариунаад /-д зөвшөөрсүгэй.

3. Тухайн ажлыг зохион байгуулах, энэхүү тушаалын хэрэгжилтэнд мэргэжлийн дагуу хяналт тавьж, ажиллахыг албаны хүний нөөцийн мэргэжилтэн /Б.Сүхбаатар/-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХЦОГ